



# ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ᠳᠣᠷᠨᠣᠭᠣᠪᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠨᠢᠶᠭᠦᠮ, ᠡᠳᠢᠶᠢᠨ ᠵᠠᠰᠭᠢᠨ  
ᠲᠠᠨᠢᠯᠴᠠᠭᠤᠯᠠᠭ᠎ᠠ

## ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2020/07



Мэдээллийн нэгдсэн лавлах: [WWW.1212.MN](http://WWW.1212.MN)

## ГАРЧИГ

Товч танилцуулга.....	1-14
Нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	15
Нэг. Эрүүл мэнд.....	16-17
Хоёр. Хөдөлмөр эрхлэлт .....	18-20
Гурав. Нийгмийн даатгал, халамж.....	21-24
Дөрөв. Гэмт хэрэг.....	25-26
Тав. Мөнгө,зээл .....	27
Зургаа. Төсөв, санхүү .....	28-29
Долоо. Үнэ.....	30-33
Найм. Хөдөө аж ахуй .....	34-36
Ес. Аж үйлдвэр.....	37-41
Арав. Барилга .....	42-44
Арван нэг. Байгаль орчин.....	45

## ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

( 2020 оны 07 дугаар сарын байдлаар)

### Нэг. Нийгмийн үзүүлэлт




#### 1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2020 оны 07 сард 823 эх амаржиж, 831 хүүхэд шинээр мэндэлж, 194 хүн нас барсан байна. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 76(10.2%)-аар, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 81(10.8%)-ээр тус тус өсч, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 28(12.6%)-аар буурсан байна.

Хүн амын цэвэр өсөлт 637 болж 2019 оны мөн үеийнхээс 109(20.6%)-өөр өссөн байна. 1000 хүнд ногдох төрөлт 11.8, нас баралт 2.8 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.9 пунктээр өсч, нас баралт өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр буурсан байна.

*Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2017-2020 оны 07 сард*



Он гарсаар нялхсын эндэгдэл 10 байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.5 дахин өсчээ.



#### 1.2 Эрүүл мэнд

2020 оны эхний 07 сарын байдлаар 227.6 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 0.9 хувиар, 10.4 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар, 6.7 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 24.1 хувиар тус тус өсчээ.




2020 оны эхний 07 сард 1031 эх жирэмсний хяналтанд орсны 90.6 хувь буюу 934 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 2.3 пунктээр өссөн байна.

Түргэн тусламжийн дуудлага 11.6 мянган удаа гарсны 2.1 мянга буюу 18.1 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал алсын дуудлага өмнөх оны мөн үеэс 10.5 хувиар өсч, нийт түргэн тусламжийн дуудлага өмнөх оны мөн үеэс 0.9 хувиар буурсан байна.

Он гарсаар ослын улмаас 1719 хүн бэртэж, 33 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 23(1.3%)-аар, нас барсан хүний тоо 16(32.7%)-аар тус тус буурсан.

*Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2020 оны 07 сард*



Цусны эргэлтийн тогтолцооны өвчин 26.4 хувь, нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд хавдар 25.9 хувь, бусад төрлийн өвчин 22.3 хувь, осол, гэмтэл хордлого гадны шалтгаант үхэл өвчин 17.1 хувь, хоол шингээх эрхтний өвчин 8.3 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 417 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 166-аар буюу 28.5 хувиар буурчээ. Халдварт өвчний тохиолдол буурахад тэмбүү 30.4 хувиар, трихоминиаз 41.1 хувиар, сүрьеэ 23.6 хувиар, бусад төрлийн өвчин 44.6 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.




### 1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2020 оны 07 сарын эцэст 411 болсны 351 (85.4%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 60 (14.6%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 210 (33.8%) хүнээр, өмнөх сараас 38 (8.5%) хүнээр тус тус буурчээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 215(52.3%) нь бүрэн дунд, 95(23.1%) нь дээд, 36(8.8%) нь тусгай дунд, 30(7.3%) нь бүрэн бус дунд, 23(5.6%) нь техник мэргэжлийн, 7(1.7%) боловсролгүй, 4(1.0%) бага боловсролтой, 1(0.2%) магистр, докторын боловсролтой иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2020 оны 07 сарын эцэст




Хөдөлмөрийн хэлтэст 2020 оны эхний 7 сарын байдлаар 181 иргэн шинэ ажлын байранд орж, бүртгэлтэй байсан 246 иргэн ажилд зуучлагдан орж, өмнөх сарын бүртгэлээс 196 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар хасагдсан байна.



#### 1.4 Нийгмийн даатгал, халамж


Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2020 оны 07 сарын байдлаар 24041.6 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 72.6 (0.3%) сая төгрөгөөр буурсан байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2020 оны 07 сард өмнөх оны мөн үеэс 72.6 сая төгрөгөөр буурахад тэтгэврийн даатгал 142.5 (0.9%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 11.4(0.7%) сая төгрөгөөр буурсан байна.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2020 оны 07 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 34554.0 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 5225.6(17.8%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 25447.5(73.6%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 4381.1(12.7%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 2083.5(6.0%) сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 1680.0(4.9%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 961.9(2.8%) сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төг






Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2020 оны 07 сард нийгмийн халамжийн сангаас 22333 иргэнд 5153.3 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 748(3.2%)-аар буурч, олгосон тэтгэвэр тэтгэмж 277.6(5.7%) сая төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2020 оны 07 сард 1338 хүн хамрагдсан нь өмнөх оноос 23(1.7%)-аар буурч, олгосон тэтгэвэрийн хэмжээ 538.7(36.4%) сая төгрөгөөр өсчээ.


Нийгмийн нөхцөлт мөнгөн тусламжийг 1120 иргэнд 641.7 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 1011 иргэнд 494.8 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 7522 иргэнийг хамруулж, 608.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бусад төрлийн халамжийн үйлчилгээнд 11342 иргэн хамрагдаж, 1391.9 сая төгрөгийг олгожээ.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /сая. төг/






## 1.5 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2020 оны эхний 07 сарын байдлаар 249 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 62 хүн гэмтэж, 10 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 107 (30.1%)-оор, гэмтсэн хүний тоо 71 (53.4%) -ээр, нас барсан хүний тоо 9 (47.4%)-өөр тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 4(3.0%)-өөр, нийтийн ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 2(50.0%)-оор тус тус өсч, хүн амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 2(18.2%)-оор, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 65(59.6%)-аар, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 13(61.19)-аар, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 16(55.2%)-аар, улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг 6(31.6 %)-аар, авилгын гэмт хэрэг 3(75.0%)-аар тус тус буурч, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, цэргийн албаны эсрэг гэмт хэрэг, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сараар




Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 54.6 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 17.7 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 5.2 хувийг улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг, 5.2 хувийг хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, 5.2 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 3.6 хувийг хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 8.5 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Сogтуугаар үйлдсэн гэмт хэрэг 42 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41(49.4%)-ээр буурсан байна.



Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Айраг, Алтанширээ, Дэлгэрэх, Мандах, Өргөн, Сайхандулаан, Улаанбадрах сумдад нэмэгдэж, бусад сумдад гэмт хэргийн тоо буурсан байна.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 1814.2 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 915.6(33.5%) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 547.6(30.2%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 42(16.9%) нь согтуугаар, 38(15.3%) нь гэр орон сууцандаа, 34(13.7%) нь гудамж олон нийтийн газарт, 25(10.0%) бүлэглэн, 30(12.0%) хувийг эмэгтэй хүн болон хүүхэд оролцон, 75(30.1%) нь шөнийн цагаар /22-06 цагт/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 644 хүн саатуулагдаж, 137 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 2020 оны 07 сард



## Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт




### 2.1 Мөнгө, банк

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын зээлдэгчийн тоо 36.1 мянга болж өмнөх оноос 2.7(8.1%) мянган хүнээр өсч, нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо 71.6 мянга болж өмнөх оны мөн үеээс 0.6 хувиар буурсан байна.

Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2019-2020 он, сая.төг



Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2019- 2020 он, мян.хүн




Нийт хадгаламжийн үлдэгдэл 137.8 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1924.3 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 1979.5 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Хадгаламжийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22.0(19.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл сарын эцэст 6.5 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 0.7(9.8%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 2.5(61.4) тэрбум төгрөгөөр өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.5 хувийг эзэлж, өмнөх сараас 0.2 пунктээр буурч, өмнөх оны мөн үеэс 1.1 пунктээр өсчээ.

Чанаргүй зээл сарын эцэст 11.7 тэрбум төгрөг болж өмнөх сараас 0.2(1.8%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 4.7(67.0%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.5 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 2.0 пунктээр өссөн байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2020.07 сард



Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2020.07 сард




## 2.2 Төсөв, санхүү

2020 оны 07 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 21913.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 77.4 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 50.4 хувиар буурсан байна / 2020 оны орон нутгийн төсвийн орлогод улсын төсөв, орон нутгийн төсөв хоорондын шилжүүлсэн орлогын дүн тусгагдаагүй/. Аймгийн орон нутгийн

төсвийн орлогын 76.4 хувийг татварын, 23.6 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2020 оны 07 сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр, ус бохирдуулсны төлбөр нийт 5577.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг өмнөх оны мөн үеэс 16.7 хувь буюу 796.4 сая.төг-өөр, төлөвлөгөөнөөс 11.2 хувь буюу 562.2 сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



### 2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2020 оны 07 дугаар сарыг өмнөх сартай харьцуулахад 0.4 хувиар, өмнөх оны мөн үеэс 4.6 хувиар тус тус өсчээ.


**Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 0.4 хувиар өсөхөд:** хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 1.0 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 0.1 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 0.7 хувь, тээврийн бүлэг 0.5 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

**Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.6 хувиар өсөхөд:** хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 10.9 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 1.9 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 6.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 1.9 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 6.3 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 2.2 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 0.1 хувь, амралт чөлөөт цаг соёлын барааны бүлэг 0.1 хувь, боловсролын үйлчилгээний бүлэг 9.9 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 3.4 хувь, бусад бараа үйлчилгээний үнэ 0.7 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2020 оны 07 дугаар сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2019-2020 оны үнийн өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2016 -2020 оны 07 дугаар сар (өмнөх оны 12-р сар=100)





## Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт




### 3.1 Хөдөө аж ахуй

Аймгийн хэмжээнд 2019 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 1010.6 мянган хээлтэгч малын 728.5 мянга (72.1%) нь 2020 оны эхний 7 сард төллөсөн байна. Эм хонины 80.3 хувь, эм ямааны 68.9 хувь, ингэний 46.2 хувь, үнээний 55.9 хувь, гүүний 47.4 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 99.9 хувь буюу 732.8 мянган төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 53.3 (7.8%) мянгаар илүү байна. Дэлгэрэх суманд 77.7 мянга, Айраг суманд 67.1 мянга, Даланжаргалан суманд 66.6 мянга, Хатанбулаг суманд 61.8 мянган, Иххэт суманд 60.6 мянган төл тус тус бойжсон нь нийт бойжсон төлийн 45.5 хувийг эзэлж байна.

Том малын зүй бус хорогдол 2020 оны эхний 7 сард аймгийн хэмжээнд 894 болж, өмнөх оны мөн үеэс 3429(79.3%) толгойгоор буурсан байна. Нийт хорогдсон малын 56.8 хувийг ямаа, 30.3 хувийг хонь эзэлж байна.

Зураг. Том малын зүй бусын хорогдол, жил бүрийн 07 сард



Малын зах зээлийн дундаж үнийн мэдээгээр нас гүйцсэн ат Улаанбадрах суманд хамгийн их буюу 1500.0 мянган төгрөг, Дэлгэрэх, Сайхандулаан, Эрдэнэ сумдад хамгийн бага буюу 1000.0 мянган төгрөг, соёолон үрээ Өргөн суманд их буюу 1100.0 мянган төгрөг, Сайхандулаан суманд хамгийн бага буюу 700.0 мянган төгрөг, хязаалан гуна Алтанширээ суманд хамгийн их буюу 2000.0 мянган төгрөг, Хөвсгөл суманд хамгийн бага буюу 870.0 мянган төгрөг байна. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Сайхандулаан суманд хамгийн их буюу 220.0 мянган төгрөг, Хатанбулаг, Сайншанд сумдад хамгийн бага буюу 150.0 мянган төгрөг, нас гүйцсэн эр ямааны дундаж үнэ Сайхандулаан суманд хамгийн их буюу 180.0 мянган төгрөг, Иххэт суманд хамгийн бага буюу 100.0 мянган төгрөг байна.



### 3.2 Аж үйлдвэр

Оны эхний 07 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 90306.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 145812.6 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах

зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 19.5 хувиар, борлуулалт 21.3 хувиар тус тус буурсан байна.

2020 оны 07 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 19.5 хувиар буурахад уул, уурхай олборлох салбарын үйлдвэрлэлт өмнөх оноос 19196.3 сая төгрөгөөр, боловсруулах салбарын үйлдвэрлэлт 5724.5 сая төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 5.3 хувийг төрийн, 94.7 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 5.3 хувь, компани 94.2 хувь, өрхийн аж ахуй 0.5 хувийг тус тус эзэлж байна.


Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ус түгээлт 51.7 мян.м3-оор, сувагжуулалт 26.3 мян.м3-аар, талх 119.8 тонноор, бялуу 0.6 тонноор, хэрчсэн гурил 23.8 мян.тн-оор, гутал 12 ширхгээр, шохой 1550 тонноор, вакуум цонх 168.8 м2-аар, цаасан уут 5.0 мян.ширхгээр, модон эдлэл 8042.5 мян.төгрөгөөр, хайрга 2.8 мян.м3-аар тус тус илүү үйлдвэрлэгджээ.



### 3.3 Барилга угсралт, их засвар

2020 оны эхний хагас жилийн байдлаар нийт 176948.5 сая төгрөгийн шинэ барилга, өргөтгөл, шинэчлэлт, их засварын ажил хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 3.5 дахин нэмэгдсэн байна. Барилгын нийт хөрөнгө оруулалтын 87.9 хувийг улсын төсвийн, 0.9 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, үлдэх хувийг хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ.

*Зураг. Барилга угсралт, их засварын ажил, төрлөөр, сая төг*





Барилга угсралт их засварын ажлын 87.6 хувь нь инженерийн барилга, байгууламж, 8.7 хувь нь орон сууцны бус барилга, 2.6 хувь нь орон сууцны барилга, 1.1 хувь нь их засварын ажил байна. Өмнөх оны мөн үеийнхээс орон сууцны бус барилгынх 18.5 пункт, орон сууцны барилгын эзлэх хувь 9.9 пункт, их засварын ажлынх 2.3 пунктээр тус тус буурч, инженерийн барилга, байгууламжийн эзлэх хувь 30.8 пунктээр нэмэгдсэн байна.

## Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



### 4.1 Байгаль орчин

#### Цаг уур

Температур: Сарын дундаж агаарын температур Мандах, Дэлгэрэх, Иххэт Эрдэнэ сумдад 21.6-23.4 градус дулаан, бусад сумдын нутгаар 24.1-26.2 градус дулаан, агаарын хамгийн их температур өдөртөө нийт сумдад 34-37 градус, 30 градусаас дулаан хоногийн тоо Дэлгэрэх, Иххэт сумдад 8-11, бусад сумдад 14-22 өдөр байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж / ОЖД /-тай харьцуулахад: Дэлгэрэх олон жилийн дундажтай ижил, Сайншанд, Замын-Үүд, Мандах, Хөвсгөл, Эрдэнэ сумд олон жилийн дунджаас 0.4-0.9 градус дулаан, бусад сумдын нутгаар 1.5-2.2 градус дулаан байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө Дэлгэрэх, Иххэт, Улаан-Уул сумдад 9-10 градус дулаан, бусад сумдад 11-14 градус дулаан, өдөртөө нийт сумдад 56-64 градус дулаан байв.

Хур тунадас: Сарын нийлбэр хур тунадас Сайншанд, Мандах, Хөвсгөл, Сайхандулаан Хатанбулаг сумдад 15.7-30.3 мм, бусад сумдын нутгаар 40.9-113.2 мм орсон байна. Сарын нийлбэр хур тунадсыг олон жилийн дундажтай харьцуулахад Сайншанд, Хөвсгөл, Сайхандулаан сумдад олон жилийн дундажийн орчим, бусад сумдад олон жилийн дундажаас ахиу байлаа.

Салхи: Энэ сард салхины хамгийн их хурд Сайншанд, Мандах, Хөвсгөл, Улаан-Уул, Замын-Үүд сумдын нутгаар секундэд 16-23 метр хүрч аюултай үзэгдлийн хэмжээнд ажиглагдсан байна. Бусад сумдын нутгаар салхины хамгийн их хурд секундад 9-14 м/с байсан. Айраг, Өргөн, Сайхандулаан, Хатанбулаг сумдад 10м/с-ээс дээш салхитай 1-7 өдөр, бусад сумдын нутгаар 12-23 өдөр байлаа.

Бэлчээрийн ургамал: 7 дугаар сарын 31-ний байдлаар бэлчээрийн ургамлын дундаж өндөр 2-12 см, бэлчээрийн ургамлын ургалт нийт нутгийн 50 хувьд буюу Айраг, Даланжаргалан, Иххэт, Өргөн сумдын ихэнх, Эрдэнэ сумын зарим хэсэг, Дэлгэрэх, Алтанширээ сумдын нутгаар сайн, 16 хувь орчимд муу, 34 хувьд дунд буюу ургалт удаашралтай байна.

МАН-н үйлдвэрлэлд: Цаг агаарын нөхцлөөс болж малын бэлчээрлэлт саатсан тохиолдол гараагүй. Сумдын нутгаар бод мал төллүүлэх, мал оторлох ажил явагдаж байна. Малын усан хангамж ихэнх нутгаар дунд зэрэг байлаа.



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**  
( 2020 ОНЫ 07 ДУГААР САРЫН БАЙДЛААР )

**I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд**

	Хэмжих нэгж	2017	2018	2019	2020	2020 2019
1. Бэлэн хүн ам, мян.хүн *	мянган	68.2	68.5	70.0	70.6	100.9
- Төрсөн хүүхдийн тоо**	тоо	727	792	750	831	110.8
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	210	234	222	194	87.4
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	517	558	528	637	120.6
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	5	8	4	10	2.7 <sup>2</sup>
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	6.9	10.1	5.3	12.0	2.4 <sup>2</sup>
2. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1 663	663	621	411	66.2
- Үүнээс эмэгтэй	тоо	821	308	308	197	64.0
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	385	153	143	96	66.8
3. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	243	176	51	181	3.5 <sup>2</sup>
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	243	76	19	99	5.2 <sup>2</sup>
Улирлын чанартай ажлын байр	тоо	0	100	32	3	9.4
Түр ажлын байр					79	
4. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	496	342	583	417	71.5
- 10000 хүнд ногдох	тоо	73	49	84	59	70.2
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	383	329	356	249	69.9
- 10000 хүнд ногдох ***	тоо	75	68	80	56	69.9
6.Бойжиж буй төл	толгой	571231	591946	679524	732820	107.8
- Унага	толгой	18331	19003	18663	23633	126.6
- Тугал	толгой	13737	15858	14566	20497	140.7
- Ботго	толгой	6342	6512	6953	7927	114.0
- Хурга	толгой	283809	292632	339672	364724	107.4
- Ишиг	толгой	249012	257941	299670	316039	105.5
7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	59978.2	112480.8	112191.1	89541.9	79.8
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	106231.2	152806.2	185187.7	145812.6	78.7

\* - 2017,2018,2019 оны жилийн эцэст

\*\*-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

\*\*\* - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



## НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

## 1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

	Хэмжих нэгж	2019 I-VII	2020 I-VII	Өсөлт	
		тоо		хувь	
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	225.6	227.6	2.0	100.9
2. Ор хоног	мян.хүн	72.0	73.0	1.0	101.4
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	5.4	6.7	1.3	124.1
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	10.0	10.4	0.4	104.0
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	11.7	11.6	-0.1	99.1
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	1.9	2.1	0.2	110.5
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	1742	1719	-23	98.7
Үүнээс: нас баралт	хүн	49	33	-16	67.3
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	1089	1031	-58	94.7
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	962	934	-28	97.1
8. Амаржсан эх	хүн	747	823	76	110.2
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	2	0	-2	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	4	10	6	3.5 <sup>2</sup>

## 1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн 07 сард

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
				хүртэл насандаа эндсэн хүүхэд	
тоо					
Дүн	823	0	831	10	0
Айраг	1		1		
Алтанширээ	1		1		
Даланжаргалан	1		1		
Дэлгэрэх					
Иххэт					
Мандах	1		1		
Өргөн					
Сайхандулаан					
Улаанбадрах					
Хатанбулаг	1		1		
Хөвсгөл					
Эрдэнэ	2		2	1	
Сайншанд	634		642	7	
Замын - Үүд	182		182	2	

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар





## 1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн 07 сард

Үзүүлэлт	2019 I-VII	2020 I-VII	Өсөлт	
	тоо	тоо	тоо	хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	583	417	-166	71.5
Вируст гепатит	5	3	-2	0.0
Сүрьеэ	55	42	-13	76.4
Тэмбүү	102	71	-31	69.6
Заг хүйтэн	141	122	-19	86.5
Трихоминиаз	95	56	-39	58.9
Цусан суулга	28	36	8	128.6
Бусад	157	87	-70	55.4

Тайлбар -<sup>2</sup>-дахин их

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



## ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

## 2.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 07 сард

Боловсролын түвшингээр	2017 VII	2018 VII	2019 VII	2020 VII	2020 VII 2017 VII	2020 VII 2019 VII
	хүний тоо				хувь	
ДҮН	1 663	663	621	411	24.7	66.2
Үүнээс: Эмэгтэй	821	308	308	197	24.0	64.0
Магистр, доктор	8	0	3	1	12.5	33.3
Дээд боловсролтой	379	99	69	95	25.1	137.7
Тусгай дунд	153	28	18	36	23.5	200.0
Техник мэргэжлийн	158	35	21	23	14.6	109.5
Бүрэн дунд	751	429	455	215	28.6	47.3
Бүрэн бус дунд	170	49	36	30	17.6	83.3
Бага	24	6	1	4	16.7	400.0
Боловсролгүй	20	17	18	7	35.0	38.9

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

## 2.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 07 сард

	Ажилгүй иргэдийн тоо		Ажилд орсон хүний тоо		Шинээр бүртгүүлсэн хүний тоо	
	2019 VII	2020 VII	2019 VII	2020 VII	2019 I-VII	2020 I-VII
ДҮН	621	411	299	776	32	1596
Айраг	7	17	2	5	0	35
Алтанширээ	3	5	17	4	0	16
Даланжаргалан	33	6	30	0	0	11
Дэлгэрэх	10	5	5	0	0	10
Иххэт	10	3	2	3	0	10
Мандах	7	23	5	0	0	25
Өргөн	10	14	72	1	0	17
Сайхандулаан	2	9	3	3	0	25
Улаанбадрах	8	6	12	38	0	54
Хатанбулаг	10	21	10	55	0	89
Хөвсгөл	5	8	5	0	0	11
Эрдэнэ	41	34	20	7	0	46
Сайншанд	350	163	55	279	18	705
Замын - Үүд	125	97	61	381	14	542

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



## 2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, 2020 оны 07 сарын эцэст

Салбарын ангилал	2019 I-VII	2020 I-VII
	Тоо	
Бүгд	321	1052
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	24	8
Уул уурхай олборлох аж үйлдвэр	126	4
Боловсруулах үйлдвэрлэл	1	1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	2	17
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын	12	41
Барилга	12	136
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн		26
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	4	9
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны	2	7
Мэдээлэл, холбоо		20
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	5	1
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа		0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл		1
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа		355
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа,	30	46
Боловсрол	20	23
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	6	30
Урлаг, үзвэр,тоглоом наадам		17
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	77	310
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа,өрхийн		0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл		0

## 2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, 2020 оны 07 сарын эцэст

Үзүүлэлт	2019 I-VII	2020 I-VII
	Тоо	
Бүгд	321	1052
Менежер	6	14
Мэргэжилтэн	38	441
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	50	54
Контор, үйлчилгээний ажилтан	22	197
Худалдаа, үйлчилгээний ажилтан	16	59
ХАА, ой загас агнуурын ажилтан	15	1
Үйлдвэрлэл, барилга,гар урлал,холбогдох ажил үйлчилгээний	11	56
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	39	33
Энгийн ажил мэргэжил	118	130
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	6	67

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



## 2.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангиллаар жил бүрийн 07 сард

Үзүүлэлт	2019 I-VII		2020 I-VII	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	тоо		тоо	
Бүгд	299	124	776	469
Менежер	4	3	5	3
Мэргэжилтэн	36	26	370	267
Техникч болон туслах дэд/мэргэжилтэн	47	19	40	25
Контор, үйлчилгээний ажилтан	20	18	184	116
Худалдаа, үйлчилгээний ажилтан	12	10	36	20
ХАА, ой загас агнуурын ажилтан	15	5	1	0
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	11	3	36	12
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	38	1	22	0
Энгийн ажил мэргэжил	111	35	79	25
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	5	4	3	1

## 2.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 2020 оны 07 сард 03 сард

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар		
			Байнга	Улирал	Түр
	тоо				
Бүгд	181	76	99	3	79
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1		1		
Уул уурхай олборлолт	2	1	1	1	
Боловсруулах үйлдвэрлэл	7	3	3		4
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж	8	3	8		
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент	30	2	30		
Барилга	33	4			33
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	23	9	13		10
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	4	4		2	2
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	13	9	8		5
Мэдээлэл холбоо	2	1	2		
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0				
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0				
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	3	1	2		1
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	1	1	1		
Боловсрол	21	15	21		
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1		1		
Урлаг үзвэр тоглоом наадам	5	5	5		
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	27	18	3		24
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй	0				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа	0				

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



## ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

## 3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 07 сард

Үзүүлэлт	2019 I-VII	2020 I-VII	2020 I-VII 2019 I-VII
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	24 114.2	24 041.6	99.7
Тэтгэврийн даатгалын сан	15231.1	15 088.6	99.1
Тэтгэмжийн даатгалын сан	1725.4	1 714.0	99.3
Эрүүл мэндийн даатгалын сан	3944.3	4 006.2	101.6
ҮОМШӨ*-ний даатгалын сан	2517.9	2 523.1	100.2
Ажилгүйдлийн даатгалын сан	695.5	709.7	102.0
Нийгмийн даатгалын сангийн зарлага	29 328.4	34 554.0	117.8
Тэтгэврийн даатгалын сан	21659.8	25 447.5	117.5
Тэтгэмжийн даатгалын сан	1695.4	2 083.5	122.9
Эрүүл мэндийн даатгалын сан	3551.3	4 381.1	123.4
ҮОМШӨ*-ний даатгалын сан	1778.4	1 680.0	94.5
Ажилгүйдлийн даатгалын сан	643.5	961.9	149.5

## 3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 07 сард

Үзүүлэлт	2019 I-VII	2020 I-VII	2020 I-VII 2019 I-VII
	хүн		хувь
1. Нийгмийн даатгалд даатгуулагчид	21296	20878	98.0
Албан журмаар даатгуулагчид	17517	17229	98.4
Аж ахуй нэгж, байгууллага	9225	8947	97.0
Төсөвт байгууллага	8292	8282	99.9
Сайн дураар даатгуулагчид	3779	3649	96.6
2. Тэтгэвэр авагчдын тоо	8638	9151	105.9
Өндөр насны тэтгэвэр	6199	6661	107.5
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1299	1349	103.8
Тэжээгчээ алдсаны	503	490	97.4
Цэргийн тэтгэвэр	448	477	106.5
ҮОМШӨ*-ний	189	174	92.1
	сая төгрөг		
3. Олгосон тэтгэвэр	23 306.0	27 120.1	116.4
Өндөр насны тэтгэвэр	15 943.7	19 078.9	119.7
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	2 555.8	2 947.8	115.3
Тэжээгчээ алдсаны	1 037.8	1 164.6	112.2
Цэргийн тэтгэвэр	1 990.3	2 248.8	113.0
ҮОМШӨ*-ний	1 778.4	1 680.0	94.5

Тайлбар: \*-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс





## 3.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сумаар

Сумын нэр	2019 I-VII	2020 I-VII	2020 I-VII 2019 I-VII
	сая төгрөг		хувь
ДҮН	24114.2	24041.6	99.7
Айраг	432.8	365.1	84.4
Алтанширээ	147.6	159.5	108.1
Даланжаргалан	1047.3	934.3	89.2
Дэлгэрэх	175.5	179.3	102.2
Иххэт	318.1	284.4	89.4
Мандах	201.0	180.6	89.9
Өргөн	854.9	406.4	47.5
Сайхандулаан	206.7	179.0	86.6
Улаанбадрах	182.4	206.7	113.3
Хатанбулаг	412.5	439.5	106.5
Хөвсгөл	190.1	188.2	99.0
Эрдэнэ	355.4	383.3	107.9
Сайншанд	13589.1	13870.3	102.1
Зүүнбаян баг	699.4	704.1	100.7
Замын-Үүд	5301.4	5560.9	104.9

## 3.4 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сумаар

Сумын нэр	2019 I-VII	2020 I-VII	2020 I-VII 2019 I-VII
	сая төгрөг		хувь
ДҮН	29328.4	34554.0	117.8
Айраг	1447.2	1627.2	112.4
Алтанширээ	545.4	628.3	115.2
Даланжаргалан	1306.6	1413.3	108.2
Дэлгэрэх	602.9	753.5	125.0
Иххэт	1049.7	1155.2	110.1
Мандах	606.8	730.0	120.3
Өргөн	1143.5	1059.3	92.6
Сайхандулаан	427.1	526.5	123.3
Улаанбадрах	645.6	735.6	113.9
Хатанбулаг	1108.3	1276.2	115.1
Хөвсгөл	540.4	634.8	117.5
Эрдэнэ	979.1	1152.5	117.7
Сайншанд	12244.2	15287.7	124.9
Зүүнбаян баг	1074.2	1224.5	114.0
Замын-Үүд	5607.4	6349.4	113.2



## 3.5 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 07 сарын эцэст

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2020 I-VII 2019 I-VII	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2020 I-VII 2019 I-VII
	2019 I-VII	2020 I-VII		2019 I-VII	2020 I-VII	
	тоо		хувь	сая төгрөг		хувь
<b>НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ</b>	<b>23081</b>	<b>22333</b>	<b>96.8</b>	<b>4875.7</b>	<b>5153.3</b>	<b>105.7</b>
<b>1. Халамжийн тэтгэвэр</b>	<b>1361</b>	<b>1338</b>	<b>98.3</b>	<b>1478.1</b>	<b>2016.8</b>	<b>136.4</b>
Ахмад настны тэтгэвэр	76	95	125.0	79.6	141.2	177.4
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	1285	1243	96.7	1398.5	1875.6	134.1
<b>2 Нөхцөлт мөнгөн тэтгэмж</b>	<b>1025</b>	<b>1120</b>	<b>109.3</b>	<b>468.8</b>	<b>641.7</b>	<b>136.9</b>
Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэнд олгосон тэтгэмж	967	1063	109.9	440.7	608.7	20.5
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	49	52	106.1	23.7	30.4	128.3
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	7	5	71.4	3.4	2.6	76.5
Ахмад настаныг гэртээ асрамжилж байгаа иргэн	2	0	0.0	1.0	0.0	0.0
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн		0			0.0	
<b>3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн</b>	<b>912</b>	<b>1011</b>	<b>110.9</b>	<b>328.6</b>	<b>494.8</b>	<b>150.6</b>
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	222	240	108.1	233.5	359.2	153.8
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	672	732	0.0	71.1	83.2	0.0
Гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/			0.0	0.0	0.0	0.0
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	6	7	0.0	12.0	14.0	0.0



## Хүснэгт 3.5-ийн үргэлжлэл

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2020 I-VII 2019 I-VII	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2020 I-VII 2019 I-VII
	2019 I-VII	2020 I-VII		2019 I-VII	2020 I-VII	
	тоо		хувь	мянган төгрөг	хувь	
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	1	4	0.0	1.2	4.8	0.0
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	8	25	0.0	9.6	30.0	0.0
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	1	1	0.0	1.2	1.2	0.0
Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, 4 ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон иргэн	2	2	0.0	2.4	2.4	0.0
<b>4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0.0</b>
<b>5. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах зардал</b>	<b>8547</b>	<b>7522</b>	<b>88.0</b>	<b>452.0</b>	<b>608.0</b>	<b>134.5</b>
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	3402	2430	71.4	123.5	134.7	109.1
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	190	191	100.5	49.9	42.7	85.6
Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн, сум, хорооны нийгмийн ажилтанд олгох урамшил	0	84	0.0	0.0	2.5	0.0
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	3822	3650	95.5	146.2	402.1	2.7 <sup>2</sup>
Банкны шимтгэл				2.7	2.7	0.0
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн зарцуулалт	1133	1167	103.0	129.7	23.3	18.0
<b>6. Бусад халамжийн дүн</b>	<b>11236</b>	<b>11342</b>	<b>100.9</b>	<b>2148.2</b>	<b>1391.9</b>	<b>64.8</b>
Алдарт эхийн одонгийн тусламж	4932	4941	100.2	653.1	631.4	96.7
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	19	19	100.0	20.5	20.4	99.7
Цалинтай ээж хөтөлбөр	3590	3477	96.9	986.1	146.8	14.9
Насны хишгийн зардал	2527	2681	106.1	405.2	423.5	104.5
Өрх толгойлсон эх/эцэг хөтөлбөрийн зардал	168	224	0.0	83.3	169.9	0.0

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



## ДӨРӨВ. ГЭМТ ХЭРЭГ

## 4.1 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, төрлөөр, жил бүрийн 07 сард

Хэргийн төрөл	2019 I-VII	2020 I-VII	зөрүү	Хэргийн бүтэц	
				2019 I-VII	2020 I-VII
				тоо	хувь
<b>Бүртгэгдсэн гэмт хэрэг - ДҮН</b>	356	249	-107	100.0	100.0
Хүн амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	11	9	-2	3.1	3.6
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	21	8	-13	5.9	3.2
Хүний эрүүл мэндэд хохирол учруулсан	109	44	-65	30.6	17.7
Өмчлөх эрхийн эсрэг	132	136	4	37.1	54.6
Хулгайлах	61	57	-4	17.1	22.9
Залилах	21	32	11	5.9	12.9
Гээгдэл эд зүйл ашиглах	10	5	-5	2.8	2.0
Хөрөнгө завших	18	11	-7	5.1	4.4
Эд хөрөнгө устгах, гэмтээх	5	2	-3	1.4	0.8
үүнээс: Дээрэмдэх	1	6	5	0.3	2.4
Авто тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр авч явах	1			0.3	
Бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх үрэгдүүлэх	1	1	0	0.3	0.4
Мал хулгайлах	14	22	8	3.9	8.8
Улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн	19	13	-6	5.3	5.2
Авилгын гэмт хэрэг	4	1	-3	1.1	0.4
